



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим
арга хэмжээний тухай

Соёл урлагийн их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Засгийн газрын 2008 оны 50, 2013 оны 38, 2016 оны 193 дугаар тогтоолыг зөрчиж, төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газарт зөвшөөрөлгүйгээр орон сууц бариулсан, хичээлийн III байрны эзэмшил газарт бусад хуулийн этгээд хашаа, барилга барьсан асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж 512.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж, 19.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 531,8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Соёл урлагийн их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Соёл урлагийн их сургуулийн Удирдах Зөвлөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Соёл урлагийн их сургуулийн захирал Э.Сонинтогос-д дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2. Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

3.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэж байгааг цаашид таслан зогсоох;

3.4. Хичээлийн III байрны эзэмшил газарт зөвшөөрөлгүй барьсан барилга, хашааг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж, газар чөлөөлүүлэх арга хэмжээ авах;


3.5. Радио, телевиз, медиа урлагийн сургуулийн хичээлийн байр нь газрын гэрчилгээгүй байгаа асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

0000117

3.6. Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд орших Нийслэлийн Засаг даргын 2004 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 452 тоот захирамжаар тухайн үеийн Соёлын дээд сургуулийн эзэмшлийн 0.045 га талбайд багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, сургуулийн эзэмшлийн газар дээр барьсан орон сууцны барилгын хэсэгт хамаарах газрын асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Барилга хот байгуулалтын яамны хамтарсан Ажлын хэсэгт танилцуулах;

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн
65 дугаар тогтоолын хавсралт

"Соёл урлагийн их сургууль" улсын төсөвт үйлдвэрийн газрын
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	512.5	Үндсэн хөрөнгө олж авахад зөвшөөрөл авах
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	19.3	Худалдан авах ажиллагааг тооцоо судалгаатай төлөвлөж, зохион байгуулж, тайлагнах, төлөвлөгөө болон үр дүнг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж байх
Зөрчил, дутагдлын нийт дүн			531.8	